

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

---

20 19 оны 06 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар А/1231 А/159

Улаанбаатар  
хот

Жагсаалт батлах, тушаал, журамд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2017 оны А/269, А/242 дугаар тушаалын 1 дэх хэсгийн “хавсралтаар” гэснийг “нэгдүгээр, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон цагдаагийн байгууллага хооронд солилцох мэдээллийн жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус” гэж өөрчилсүгэй.

2. “Солилцох мэдээллийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

3. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам”-ын 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.7 дахь хэсгийг нэмсүгэй.

1/“3.7. Мэдээллийн санг хувийн зорилгоор ашиглах, мэдээллийг бусдад дамжуулахыг хориглоно.”.

4. Мөн журмын 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6 дахь хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

1/“3.2. Эрүү, иргэн, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн сан болон цагдаагийн байгууллагын гэмт хэргийг илрүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн сан /АСАП сан, гэмт хэрэг, зөрчлийн, эрүүлжүүлэгдсэн этгээд, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн сан г.м/-гийн мэдээллийг харилцан солилцоно.

3.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий алба хаагч шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн, эрэн сурвалжлагдаж байгаа ялтан, этгээд, төлбөр төлөгч, тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийн талаарх мэдээллийн нэгтгэн, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “АСАП” санд оруулж, зарлан мэдээлэх ажиллагааг цагдаагийн байгууллага явуулна.

3.4. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн, эрэн сурвалжлагдаж байгаа ялтан, этгээд, төлбөр төлөгч, тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийг олж тогтоон хуульд заасны дагуу саатуулах, хураан авах ажиллагаа явуулж, мэдээлэл ирүүлсэн эрх бүхий байгууллага, алба хаагчид мэдэгдэнэ.

3.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ журмын 3.4-д заасны дагуу саатуулсан ялтан, этгээд, төлбөр төлөгч, хураан авсан тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийг даруй хүлээн авна.

3.6.Энэ журмын 3.3 дахь хэсэгт заасан алба хаагч нь сангийн баяжилт, бүрдүүлэлтэд хяналт тавьж, эрэн сурвалжлагдаж байгаа ялтан, этгээд, төлбөр төлөгч, тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийг хүлээн авсан тохиолдолд “Асап” санд эрэн сурвалжлалтыг зогсоож, мэдээллийн сангаас тухай бүр хасалт хийнэ.”.

5.Мөн журмын 1.3.2 дахь заалтын “алба” гэснийг “газар” гэж өөрчилсүгэй.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга /хурандаа А.Намсаманд/, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга /цагдаагийн хурандаа Р.Отгонжаргал/ нарт тус тус даалгасугай.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА  
Д.ДАМДИНЦЭРЭН

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
Р.ОТГОНЖАРГАЛ

ШШГЕГ, ЦЕГ-ын даргын хамтарсан  
2019 оны 06 дугаар 06 сарын 26 -ны  
өдрийн 4123, 4159 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

УХГ0025

## СОЛИЛЦОХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цагдаагийн байгууллагаас мэдээлэл авах өгөгдлийн утгууд
  - 1.1. Торгуулийн мэдээллийн сан – 3100, 3110
    - Оролтын утга:
      - Регистрийн дугаар
    - Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/
      - 1.1.1. Регистр
      - 1.1.2. Эцэг/эх-ийн нэр
      - 1.1.3. Өөрийн нэр
      - 1.1.4. Төрсөн огноо
      - 1.1.5. Торгуулийн хэмжээ
      - 1.1.6. Зөрчил гаргасан огноо
      - 1.1.7. Зөрчлийн зүйл анги
      - 1.1.8. Цагдаагийн газар, хэлтэс
      - 1.1.9. Бүртгэлийн дугаар
  - 1.2. Зөрчлийн мэдээллийн сан – 3112
    - Оролтын утга:
      - Регистрийн дугаар
    - Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/
      - 1.2.1. Регистр
      - 1.2.2. Эцэг/эх-ийн нэр
      - 1.2.3. Өөрийн нэр
      - 1.2.4. Төрсөн огноо
      - 1.2.5. Зөрчил гаргасан огноо
      - 1.2.6. Зөрчлийн зүйл анги
      - 1.2.7. Зөрчлийн товч утга
      - 1.2.8. Зөрчлийг шийдвэрлэсэн огноо
      - 1.2.9. Зөрчлийн шийтгэврийн төрөл
      - 1.2.10. Шийтгэлийн хэмжээ
      - 1.2.11. Хоног
      - 1.2.12. Хугацаа
  - 1.3. Гэмт хэргийн мэдээллийн сан
    - Оролтын утга:
      - Регистрийн дугаар
    - Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/
      - 1.3.1. Регистр
      - 1.3.2. Эцэг/эх-ийн нэр
      - 1.3.3. Гэмт хэрэг гарсан огноо
      - 1.3.4. Оршин суугаа хаяг
      - 1.3.5. Өөрийн нэр
      - 1.3.6. Төрсөн огноо
      - 1.3.7. Эрүүгийн хуулийн зүйл анги
      - 1.3.8. Цагдаагийн газар, хэлтэс
      - 1.3.9. Хэргийн дугаар

- 1.3.10. Хэргийн утга
- 1.4. Эрүүлжүүлэгдсэн этгээдийн мэдээллийн сан
  - Оролтын утга:
    - Регистрийн дугаар
  - Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/:
    - 1.4.1. Цагдаагийн газар, хэлтэс
    - 1.4.2. Бүртгэлийн дугаар
    - 1.4.3. Огноо
    - 1.4.4. Регистр
    - 1.4.5. Ургийн овог
    - 1.4.6. Эцэг/эх-ийн нэр
    - 1.4.7. Өөрийн нэр
    - 1.4.8. Утга
- 1.5. Жолоодох эрх түдгэлзүүлсэн мэдээллийн сан
  - Оролтын утга:
    - Регистрийн дугаар
  - Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/:
    - 1.5.1. Регистрийн дугаар
    - 1.5.2. Эцэг/эх-ийн нэр
    - 1.5.3. Өөрийн нэр
    - 1.5.4. Төрсөн огноо
    - 1.5.5. Жолооны үнэмлэхний дугаар
    - 1.5.6. Жолооны үнэмлэхний төлөв
    - 1.5.7. Жолооны үнэмлэхний хүчинтэй огноо
    - 1.5.8. Эрх түдгэлзүүлсэн огноо
    - 1.5.9. Тайлбар
    - 1.5.10. Эрх түдгэлзүүлсэн шалтгаан
    - 1.5.11. Нэмэлт мэдээлэл
- 1.6. Эрэн сурвалжилж буй этгээдийн мэдээллийн сан
  - Оролтын утга:
    - Регистрийн дугаар
    - Эцэг/эхийн нэр
    - Өөрийн нэр
  - Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/:
    - 1.6.1 Регистер
    - 1.6.2 Овог нэр
    - 1.6.3 Өөрийн нэр
    - 1.6.4 Төрсөн огноо
    - 1.6.5 Хүйс
    - 1.6.6 Содон шинж тэмдэг
    - 1.6.7 Биеийн өндөр, жин
    - 1.6.8 Биеийн болон өмсөж явсан хувцасны талаарх мэдээлэл
    - 1.6.9 Цээж зураг
    - 1.6.10 Одоо амьдарч буй хаяг
    - 1.6.11 Утга
    - 1.6.12 Анхаарах зүйл
    - 1.6.13 Эрэн сурвалжилж буй алба, газар, хэлтсийн нэр
    - 1.6.14 Эрэн сурвалжлагдаж буй төрөл
    - 1.6.15 Эрэн сурвалжилж эхэлсэн огноо, олдсон огноо
    - 1.6.16 Эрэн сурвалжилж буй алба хаагчийн нэр, албан тушаал хаяг холбоо барих утас

2. Цагдаагийн байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас мэдээлэл авах өгөгдлийн утгууд

2.1. Хорих ял эдэлж буй болон эдэлж байсан этгээдийн мэдээлэл:

- Оролтын утга:
  - Регистрийн дугаар
  - Эцэг эхийн нэр, өөрийн нэр
- Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/:
  - 2.1.1. Регистрийн дугаар
  - 2.1.2. Ургийн овог
  - 2.1.3. Эцэг эхийн нэр
  - 2.1.4. Нэр
  - 2.1.5. Иргэний харьяалал
  - 2.1.6. Хүйс
  - 2.1.7. Яс үндэс
  - 2.1.8. Мэргэжил
  - 2.1.9. Боловсрол
  - 2.1.10. Эрхэлж байсан ажил
  - 2.1.11. Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нэр
  - 2.1.12. Цагдан хорих шийдвэр
  - 2.1.13. Төлөв /Сэжигтэн, Яллагдагч, Шүүгдэгч.../
  - 2.1.14. Хоч
  - 2.1.15. Хэргийн дугаар
  - 2.1.16. Хэргийн зүйл анги
  - 2.1.17. Хэрэг үйлдсэн огноо
  - 2.1.18. Шалтгаан
  - 2.1.19. Ялын хугацаа
  - 2.1.20. Хорьж эхлэх огноо
  - 2.1.21. Цагдан хорих хугацаа
  - 2.1.22. Хасагдах шийдвэр
  - 2.1.23. Хасагдах шалтгаан
  - 2.1.24. Хасагдсан огноо
  - 2.1.25. Хасагдсан нэмэлт мэдээлэл

2.2. Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй болон эдэлж байсан этгээдийн мэдээлэл:

- Оролтын утга:
  - Регистрийн дугаар
- Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх бөгөөд энэ нь олон удаа ял эдэлсэн бол тухай бүрийн мэдээллийг агуулна/:
  - 2.2.1. Регистрийн дугаар
  - 2.2.2. Ургийн овог
  - 2.2.3. Эцэг эхийн нэр
  - 2.2.4. Нэр
  - 2.2.5. Иргэний харьяалал
  - 2.2.6. Хүйс
  - 2.2.7. Яс үндэс
  - 2.2.8. Мэргэжил
  - 2.2.9. Боловсрол
  - 2.2.10. Эрхэлж байсан ажил
  - 2.2.11. Оршин суух хаяг
  - 2.2.12. Утас
  - 2.2.13. Алба, хэлтэс

- 2.2.14. Хувийн хэргийн дугаар
- 2.2.15. Шийтгэх тогтоол
- 2.2.16. Зүйл анги
- 2.2.17. Нэмэлт зүйл анги
- 2.2.18. Ялын төрөл /Торгох, Нийтэд тустай ажил хийлгэх.../
- 2.2.19. Ялын хэмжээ
- 2.2.20. Хүлээн авсан огноо
- 2.2.21. Дуусгавар болсон тогтоол
- 2.2.22. Дуусгавар болох төрөл
- 2.2.23. Дуусгавар болох үндэслэл
- 2.2.24. Дуусгавар болсон огноо
- 2.2.25. Гүйцэтгэл

2.3. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцсон талаар мэдээлэл:

- Оролтын утга:
  - Хариуцагчийн регистрийн дугаар
  - Нэхэмжлэгчийн регистрийн дугаар
- Гаралтын утга /жагсаалт хэлбэрээр байх/:
  - 2.3.1 Регистрийн дугаар
  - 2.3.2 Нэхэмжлэгчийн эцэг эхийн нэр
  - 2.3.3 Нэхэмжлэгчийн нэр
  - 2.3.4 Хариуцагчийн регистрийн дугаар
  - 2.3.5 Хариуцагчийн эцэг эхийн нэр
  - 2.3.6 Хариуцагчийн нэр
  - 2.3.7 Гүйцэтгэх хуудасны огноо
  - 2.3.8 Гүйцэтгэх хуудасны дугаар
  - 2.3.9 Байгууллагын нэр
  - 2.3.10 Хувийн хэргийн дугаар
  - 2.3.11 Хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийн тойргийн дугаар
  - 2.3.12 Байгууллагын төрөл
  - 2.3.13 Шийдвэрийн дугаар
  - 2.3.14 Шийдвэрийн төрөл
  - 2.3.15 Шийдвэрийн огноо
  - 2.3.16 Төлбөрийн хэмжээ
  - 2.3.17 Төлбөр төлөлтийн хэлбэр
  - 2.3.18 Дэлгэрэнгүй
  - 2.3.19 Дуусгавар болсон тогтоол
  - 2.3.20 Дуусгавар болсон төрөл
  - 2.3.21 Дуусгавар болсон шалтгаан
  - 2.3.22 Дуусгавар болсон огноо

09

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

---

2012 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/260<sup>а</sup>/242

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга /хурандаа М.Алтан-Очир/, Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Д.Ядамдорж/ нарт тус тус даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр нэгтгэн танилцуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Тусгай ажиллагаа, аюулгүй байдлын газрын дарга /хурандаа П.Хосбаяр/, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга /цагдаагийн хурандаа Ж.Амгалан/ нарт тус тус үүрэг болгосугай.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ж.АМГАЛАНБАЯР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

С.БААТАРЖАВ



## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА, ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээд, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн албаны үйл ажиллагаатай холбогдуулан түүний амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн тохиолдолд цагдаагийн байгууллагаас туслалцаа үзүүлэх, харилцан мэдээлэл солилцоход оршино.

1.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд туслалцаа үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах үйл ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цагдаагийн албан тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.3. Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр дараах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 100.7, 189.6, 190.4, 250.1 дэх заалтын хэрэгжилтийг хангаж, харилцан мэдээлэл солилцох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий алба хаагчийн хүсэлтээр хамтран ажиллах;

1.3.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162.6, 180.3, 187.2, 239.5-д тус тус заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт ялтан, хоригдол, тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд цагдаагийн алба хаагч хуульд заасны дагуу хяналт тавих.

Тайлбар: "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэр" гэж суманд шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хэлтэс, тасаг байгуулаагүй байхыг ойлгоно.

1.4. Энэ журмын 1.3.2-т заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж, хамтран ажиллахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэжил арга зүйн тусламж, дэмжлэг, зөвлөмжөөр ханган ажиллана.

1.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллага нь энэхүү журмыг баримтлан аливаа асуудлыг тухай бүр хамтран шийдвэрлэнэ.

### Хоёр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд хамтран ажиллах

2.1. Цагдаагийн байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий алба хаагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тавьсан үндэслэл бүхий хүсэлтийг хүлээн авч, дараах шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамтран ажиллана:

2.1.1. орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга, байгууламжийг нураах тухай шийдвэрийг гүйцэтгэх;



2.1.2.нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаа;

2.1.3.эрх хасах ял шийтгүүлсэн ялтан д хяналт тавих;

2.1.4.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд хяналт тавих;

2.1.5.үүрэг гүйцэтгэх, эрх хязгаарлах, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх;

2.1.6.албадан эмчлүүлж байгаа этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2.1.7.чөлөөгөөр явах хоригдол, түүний батлан даагчийг чөлөөгөөр зорчиж буй хугацаанд бүртгэх;

2.1.8.оргосон хоригдол, хоригдсон этгээдийг мөрдөн хөөх, баривчлах ажиллагааг гүйцэтгэх.

2.2.Орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга, байгууламжийг нураах тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд туслалцаа авах талаар ахлах шийдвэр гүйцэтгэгч тухайн ажиллагаа явагдахаас ажлын 5 хоногийн өмнө холбогдох баримт бичиг, мэдээлэл, хүсэлтийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

2.3.Энэ журмын 2.2-т заасан хүсэлтийг үндэслэн цагдаагийн хамгаалалт авах шаардлагатай тохиолдолд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчийг ажиллуулна. Хүсэлтийг хангах үндэслэлгүй бол тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлэхээс 24 цагийн өмнө хүсэлт гаргасан эрх бүхий байгууллага, алба хаагчид бичгээр мэдэгдэнэ.

2.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд туслалцаа үзүүлэхтэй холбогдон гарсан зардлыг иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас суутган тооцно.

2.5.Энэ журмын 2.1.2, 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.7-д заасан ажиллагааг хамтран хэрэгжүүлэхдээ шийдвэр гүйцэтгэгч нь холбогдох баримт бичгийн хуулбар, гүйцэтгэх хугацаа, бусад мэдээлэл /овог нэр, нас, хүйс, оршин суугаа хаяг, төрөл садангийн хүмүүсийн мэдээлэл, цахим хаяг, холбоо барих утасны дугаар, содон шинж тэмдэг, хилийн хориг тавьсан шийдвэр, түүний хугацаа, оршин суугаа хаягаа өөрчилсөн тухай, гадаадад зорчих гэх мэт/-ийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

2.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт энэ журмын 2.1.2, 2.1.3, 2.1.4-т заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага бүртгэл хөтөлж, энэ талаар 30 хоног тутамд мэдээг тухайн нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлнэ.

2.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуульд заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулахад дараах тохиолдолд цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэнэ.

2.7.1.хорих анги болон албадан эмчлүүлж байгаа этгээд оргосон, гэмт хэрэг үйлдэгдсэн;

2.7.2.хорих анги, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг биелүүлж буй эмнэлгийн байранд эмх замбараагүй байдал үүссэн;

2.7.3.алба хаагчийн албаны үйл ажиллагаатай холбогдуулан түүний болон гэр бүлийн гишүүний амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн, халдсан.

2.8.Энэ журмын 2.7.1-д заасан хоригдол, холбогдох хүн, хуулийн этгээдийн талаар холбогдох бүхий л мэдээллийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад даруй хүргүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд эрэн сурвалжлах ажлыг хамтран зохион байгуулж, тухай бүр мэдээлэл харилцан солилцоно.

2.9.Энэ журмын 2.7.2-т заасан мэдээлэл хүлээн авсан даруйд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь нийтийн эмх замбараагүй байдлын үед дэг журам сахиулах арга хэмжээ авна.

**Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох**

3.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд туслалцаа авахдаа холбогдох баримт бичгийг хуулбарлан, шаардлагатай бусад мэдээллийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

3.2.Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээдийг “Эрэн сурвалжлах сан”-д бүртгэн, зарлан мэдээлэх ажиллагааг цагдаагийн байгууллага явуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд туслалцаа үзүүлнэ.

3.3.Иргэний, захиргааны, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглагдаж байгаа цахим сан болон цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах сангийн мэдээллийг харилцан солилцоно.

3.4.Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээд, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтооход шаардлагатай мэдээллийг цагдаагийн байгууллага тухай бүр гарган өгнө.

3.5.Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээд, эрэн сурвалжлагдаж буй тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийг олж тогтоон хуульд заасны дагуу саатуулах, хураан авах ажиллагаа явуулж, мэдээлэл ирүүлсэн эрх бүхий байгууллага, алба хаагчид мэдэгдэнэ.

3.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ журмын 3.5-д заасан саатуулсан хүн, хураан авсан эд хөрөнгийг даруй хүлээн авна.

**Дөрөв. Бусад зүйл**

4.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан, туслалцаа авсан, харилцан мэдээлэл солилцсон үйл ажиллагааны талаарх мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын аюулгүй байдал хариуцсан нэгжид ирүүлнэ.

4.2.Журмын хэрэгжилтийн талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хагас, бүтэн жилээр харилцан мэдээлэл солилцож, хамтын ажиллагааны үр дүнг үндэслэн алба хаагчдыг урамшуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж болно.

4.3.Энэ журмыг хэрэгжүүлэх явцад төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд нийтэд задруулахыг хориглоно.

4.4.Энэ журмыг зөрчсөн алба хаагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.